

Сонсох дөрвөн үнэнийн судар оршуулвай

Мөнхцэрэнгийн Золзаяа *

Доктор (Ph.D), дэд профессор

Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэн

Улаанбаатар, Монгол Улс

zolzaya@mas.ac.mn

Хураангуй

“Сонсох дөрвөн үнэний судар оршуулвай”^{2*} хэмээх гар бичмэл нь XIX зууны сүүл, XX зууны эхэн үед 13x25 см хэмжээтэй муутуу цаасан дээр бийрээр бичсэн 54 хуудастай, цаас нь гэмтэлгүй хадгалагдаж ирсэн. Гар бичмэлд хэзээ хэн зохиож орчуулсан зэрэг мэдээлэл үгүй болно. Тус гар бичмэлийг шинжлэхэд Бурхан багшийн намтар, түүний “Хутагтын дөрвөн үнэн” сургаалд үндэслэж, “Абхидхармакоша” шастирын гуравдугаар бүлэг” зэргээс эшлэн тайлбарласан нь илэрхий байна. Үндэсний Номын сангийн гар бичмэлийн фондод ийм нэртэй гар бичмэл бүртгэгдээгүй байгаа болно. Энэхүү гар бичмэлийн хөрвүүлгийг анх удаа кирилл бичигт хөрвүүлэн уншигч Танаа толилуулж байна. Мэргэжлийн судлаачдын хэлэлцүүлгээр оруулах үед хятад, түвэд хэлнээс орчуулагдсан байх эсвэл зохион найруулсан болов уу гэсэн таамаглал дэвшигдсэн бөгөөд цаашид эх бичиг судлаачид илүү нарийвчлан судлах болов уу хэмээн найдаж байна.

Түлхүүр үгс: *дөрвөн үнэн, судар шастир, гар бичмэл*

* Монгол бичгээс хөрвүүлэгч



© The Author(s) 2023

<https://creativecommons.org/licenses/by/4.0/>

<https://orcid.org/0000-0001-6083-1445>

Received: 29 August 2023

Accepted: 05 October 2023

² Гар бичмэлийн цаасны хэмжээ: 13x25; Хуудасны тоо: 54; Цаас: муутуу, гэмтэлгүй; Номын хэв: Монгол бичгийн гар бичмэл; Бичгийн хэрэглэл: бийр; Номын хэлбэр: үдмэл; Юугаар бичсэн: хар бэх; Тамга тэмдэггүй. Гар бичмэлийг хадгалж буй Архангай аймгийн иргэн Ч.Алтанчимэгийн зөвшөөрлөөр хэвлэв.

The sutra of listening Four truths

Zolzaya Munkhtseren*

*Doctor (Ph.D), associate professor
Institute of Philosophy, Mongolian Academy of Sciences
Ulaanbaatar, Mongolia
zolzaya@mas.ac.mn*

Abstract:

The manuscript “The Sutra of listening four truths /Sonsoh Durvun Unenii Sudar Orchuulwai “ has 54 pages written with a brush on poor paper, 13x25 cm in size, late 19th-early 20th centuries, the paper is intact. The manuscripts have lost information such as who wrote them and who translated them. Analyzing the manuscript, one can see that it is based on the biography of Lord Buddha, his teachings on the “Four Noble Truths” and quotations from the “Third Chapter of the Abhidharmakosha Chronicle”. There are no manuscripts with this title in the manuscript collection of the National Library. This translation of the manuscript is presented to the reader for the first time in Cyrillic alphabet. In discussion by professional researchers, it has been assumed that it was translated from Chinese or a central language, or was composed, and it is hoped that the original authors will study it in more detail in the future.

Keywords: *four truths, Sacred Scriptures and manuscripts*

Хамгийг мэдэгчид мөргөмүй
Гурван ертөнцийн лам хувраг
Гурван цагийн бурхан

Гурван сансрыг тэгш удирдагч амьтан, тэнгэр хийгээд хүмүүний дээд оройн чимэг болсон Бурхан багш үнэн төгс туулсан Шигамуни бурхан тэр нэн урд туулшгүй нэгэн галавт буяны чуулган дүүрвэй. Хоёрдугаар галавт түйтгэр арилвай.

Гуравдугаар галбын эцэст эцэг нь Ариун идээт хаан, эх нь Илэй хувилгаан үзэсгэлэнт хатны умайд Живрон нэрт эм модон туулай жилийн зуны дунд сарын арван тавнаа эхийн хэвлийд орюу.

Гэмчун нэрт шороон луу жилийн хаврын эцэс сарын арван тавнаа эхийн баруун суганаас төрвэй.

Нар нь гийсэн төрөв хэмээх тэр хорин есөн нас хүртэл хааны орон суувай.

Найман түмэн дөрвөн мянган хатан авч хааны төрийг номыг зохиож суутал хааны хотын дөрвөн хаалгыг эргэн явахад өмнө хаалганд төрөх амьтныг үзвэй. Өрнө хаалганд өтлөхийн амьтныг үзвэй. Умард хаалганд өвдөхийн амьтныг үзвэй. Дорно хаалганд үхэхийн амьтныг үзвэй. Орчлонгийн зовлонд дөрвөн далайг үзэж нөхдөөсөө асуусаар орчлонгийн энэ зовлон бүгдэд буй юу эдэнд буй юу хэмээвэй. Тэндээс нөхөд харихдаа өгүүлрүүн: Энэ дөрвөн зовлон бүгдэд хүртсэн буй. Түүнээс болох чамд буй хэмээв. Үүнээс тонилохын арга юу буй хэмээв. Нөхөд өгүүлрүүн үүнээс тонилох нь орчлонг тэвчвээс тонилмуй хэмээвэй. Тийн бөгөөс хаанд айлтгаж, би орчлонг тэвчиж тойн болох хэмээн зарлиг болж хаанд очоод энэ

ертөнц бүгд бус мөн бус байнам орчлонг тэвчиж тойн болсу хэмээв.

Хаан зарлиг болруун:

Аяа хөвгүүн тэр бус, би насанд хүрэв. Чи тойн болбоос хаан хэн болох вэ? Чамд үгүй болбоос эдгээр орсон буй заа эс бөгөөс хий орсон буй заа хэмээн зарлиг болсон. Хотын дөрвөн хаалгыг бэхлэн хадуулвай. Хааны хөвгүүнд дөрвөн үнэний мөрт зорих арга ямар буй хэмээн сэтгэж хааныг суутал хурмаст тэнгэр ирж, чи үнэхээр тонилох мөрийг хүсэх бөгөөс хаврын эцэс сарын арван тавны өдөр эрт манагар шарга морь болж хувилан ирж, чамайг хаана хүссэн газарт хүргэж хэмээн болчивай. Гүдэнгийн нэрт эр гал бичин жилийн хаврын эцэс сарын арван тавны өдөр бацаг барин суутал хурмаст тэнгэр шарга моринд хувилж ирээд чи намайг өнөө шөнө хүссэн газарт хүргэвээс хэмээвэй.

Тэндээс шарга морь унаж огторгуйгаар гарч янцгаах морины хазаар суугаад зуны тэргүүн сарын шинийн найман цагаан лавайн дуун илдээр сахлын үсээ өөрөө түлж өөр биедээ өөрийн багш болж тойн болбой. Тэндээс ариун жим болтол тоосго хийгээд өвсөөр дэвсгэрлэн сууж бэрхийг чадаж Самади даяанд тэгш агуулвай. Тэндээс бааруу хэмээх төмөр үхэр жилийн хаврын эцэс сарын арван таванд бүрий цагт нисваанис шимнусыг дарвай. Шөнө дөл цагт даяаныг тэгш бясалгавай. Өглөө оройд урд номын биед илт туулсан бурхны хутгийг олбой. Эдүгээ би орчлонгийн зовлонд дөрвөн далайгаас гэтлэв. Нисваанисын дайсныг дарав. Хамаг номд илт туулсан бурхан болов би. Рашаан мэт номын ариуныг олов би.

Төгс хувьт амьтны дотор номын хүрдийг оршуульа хэмээн сэтгэж явдаг. Тэндээс заримууд амьтан хааны хөвгүүн халчирхаж очив хэмээлдэв. Заримууд нь хааны орныг тэвчиж Сэнгэ хэмээх хүний Сацума нэрт охин лүгээ нэгэн үгтэй бөлгөө хэмээн хочлолдвай. Заримууд нь хааны хөвгүүн илт туулсан бурхан мөн хэмээлдэв. Тэндээс бурхан номлоруун: Би чухал номын рашааныг олон бүх тал хэнд үзүүлбээс сонсон мэдэгч амьтангүй тул өгүүлэлдэхгүй аглагт зорьж, Арш нарын оронд дөчин ес хоног даяан бясалгалд суун атал Асур тэнгэр, мянган хигээст алтан хүрд барьж очив. Чи гагц биеийн тулд бурхан болсон бус буй за. Хамаг амьтны тусын тулд туулсан бурхан болбой за.

Чи амьтны тусын тулд номын хүрдэн оршуулан соёрх хэмээн өчсөнд эс болов. Тэндээс бас дөрвөн Махранз ирээд найман тахилыг барин уулзвай. Арван хүчний Эээн их баатар ч хамаг нисваанис дайсныг даран бөгөөтөл амьтны тусыг их үл үйлдмүй хэмээн өчвөөс эс болов. Тэндээс бас хурмаст тэнгэр тэргүүлэн гучин гурван тэнгэр нар ирж үвширгө (хуйлран) эргэсэн цагаан лавай барин үзвэй.

Эм мэт номын рашааныг олсон (эрдмийг олох) бөлгөө. Амьтныг зовлонт өвчнөөс гэтэлгээд нисваанист дарагдсанаас Дээд номын дуун дуурсан соёрх хэмээн залбиран суух атал Гоудинаяа, Датүл, Ламба, Минчэн, Сандан, тэдгээр таван гэлэнгүүд энэ Хонсам тойн үнэхээр бурхан мөн буюу бус буюу хэмээн сэтгэж Бурхан мөн бөгөөс ном сонсюу бус бөгөөс бүү мөргөө хэмээлдэв. Тийн атал Гоудинаяа сэтгэлдээ барин ирвэй. Тэндээс бурхны бие болбоос алтан өнгөтэй биеэс нэгэн алтан гэрэл гарч тавьсан суухыг үзээд Гоудинаяа гэлэн мөргөж ирээд сэцэн чуулганы мөрийг олбой. Нөгөө дөрвөн гэлэн түүнийг үзээд бишрэл төрж мөргөв. Тэндээс таван гэлэнгүүд бурханд өчив. Чи үнэмлэхүй бурхан бөгөөс Варанасын оронд мянган бурхны ширээ бэлэн, чи түүнд сууж хамаг амьтанд номын хүрд

орчуулан соёрх хэмээн залбиран мөргөмүй. Бурхны биеэс цаглашгүй гэрэл гараад Варанасд өөд болж мянган бурхны ширээнд гурвантаа мөргөж, гурвантаа эргээд Орчлонг эвдэгч бурхан,³ Алтан чадагч бурхан,⁴ Гэрэл сахигч бурхан тэдгээр гурван бурхан ширээнд сууж бүрүн мөн.

Тэр жилийн зуны дунд сарын шинийн дөрвөний өдөр нэн урьд **шавь таван аяга тахимлагд** нэн урьд зарлиг болруун: **“Дөрвөн үнэний ном”-ыг номлобой:**

Аяга тахимлагууд

Энэ хэмээвээс үлэмж зовлон үнэн буюу

Энэ хэмээвээс үлэмж хамаг зовлонгууд гарахын орон үнэн

Энэ хэмээвээс үлэмж мөр үнэн

Энэ хэмээвээс үлэмж гатлах үнэн буюу.

Аяга тахимлагууд зовлонг тэвчих хэрэг, мөр бясалган үйлдэх, гатлахыг илт үйлдэх зовлонг тэвчигдэхүй бус хамаг гарахын орныг мэдэгдэхүй. Жич бас мэдэгдэх бус мөрийг бясалгагдах бус, хаагдах илт үйлдэхүй, жич бас илт болгоогч бус, жич бас бясалгах бус, тийм хэмээн жич бас зарлиг болсонд аяга тахимлагууд дөрвөн үнэний мөрийг илт олов. Билиг билгийг төгсгөсний үүднээс чухал тонилбой. Дөрвөн үнэний дотроос тийн хэмээн **зовлон үнэнийг** номловой. Ийн хэмээн зовлонгийн үнэнийг номлох хэрэг юу хэмээвээс гурван ордын орчлонгийн эдгээр бүгд үнэмлэхүй зовлон буюу. Гурван ордын ариухан зүйл амьтанд нэгэн гэсний төдий жаргалангийн орон үгүй тул зовлон чанар мөний тул үнэмлэх зовлон хэмээгдэж, бас түүний чанар нь 18 тамын амьтныг **халуун хүйтний зовлонг** дагасан ядаж насан чинээ нь тоолшгүй галав хүртэл хэвтмүй гэлээ. Гадаад гэхээр хилэнц, дотоод гэхээр хилэнц. Идээ ундаа гэхээр хилэнц.

Бирдийн гурван аймгийн **өлсөхүй ундаасах зовлонгууд** нь цаглашгүй насны хэмжээ таван зуун наст болой. Асар нарийн байлдахул зовлонгууд нь өдөр бүр түмэнтээ үхэж, түмэнтээ итгэж цаглашгүй зовлон буюу насны чинээ нь гурван зуун наст болой. Адгуусан амьтны зовлон нь унах, ачих, хэлгий, мунхаг цаглашгүй зовлонд буй. Насны чинээ нь урт наст их галав буюу. Биеийн хэмжээ нь багыг **өвдөхүй, үхэх** цаглашгүй зовлон мөний тул **төрөхийн зовлон** нь өөрийн биеэ улаан төмрийн нүхээр шувтарч хаясан мэт мэдээтэй мэдэхгүй лугшиж хэвтэх цаглашгүй зовлон буюу.

Өглөхийн зовлон нь үс цайж нүүр нь эндүүрэм сарьслаад биеийн мах барагдаж, цус нь хатаж, бие нь бөхийж, нүдэнд уул үл үзэгдэх. Чихэнд нь бүрээний дуун үл сонсож, шүд нь тараг үл дааж, хамраар үнэр үл үнэрлэж, биеийн хүч барагдаж, таяг тулж, сэтгэл нь мартамхай тунгааж амтат идээг үл мэдэж, **өглөхийн зовлон** энэ буюу. **Өвдөх зовлонгууд** нь цаглашгүй буй. Хий, шар, бадган тэргүүтэн 424 өвчин. Ер өвчин хүрсэн зовлон нь явбаас суух дуртай. Сууваас явах дуртай босвоос хэвтэх дуртай. Хэвтвээс босох дуртай. Хоолойд шахаж дотор нь хий дүүрч өдөр шөнөжин хараад хоног урт, амтат идээ мод мэт. Хэв мэт зөөлөн тэр дэвсгэр нь өргөс шивээ мэт.

Цагаан нүд, шүдээр шарлаж, улаан мах цус хөрж, сэтгэл нь хутгалдаж авир нь их болж, ийм зовлонгоос хэзээ тонилмуй гэж загас халуун элсэд орхисон мэт

³ Сайн цагийн мянган бурхны анхдагч бурхны нэр. Krakuchanda

⁴ Сайн цагийн мянган бурхны хоёрдогч бурхны нэр. Kanakamuni

дасаж ядмуй. **Өвчний цаглашгүй зовлонгууд** ийм болой. **Үхэхийн зовлон** нь чухал нөхөр сүүдрээр хүрээлүүлж гомдон гасалж илбэсэн харанхуй хийгээд бие нь уул унасан мэт бие нь чичирмүй. Сэтгэл нь их салхин доторх зул мэт үймэрнэ. Эрлэгүүдийн догшин ер дүрс нүдэнд үзэгдэх буюу. Түүнээс махбод шингэхүйн зэрэг шороо усанд шигдэх. Бэлгэ нь ам, хамар гашуун, хатуу хэл нь татаж дотрын бэлгэ нь утаан мэт болж хэмээн хийд шингэх. Хатуу бэлгэ нь биеийн толгой нь улам бууж гаднаас дотогш сэтгэх. Дотрын бэлгэ нь галт хорхой мэт буюу. Хий сэтгэлд сэтгэхүй гадаад бэлгэ нь амин гадагш урт харайж дотогш хураан үл чадмуй. Нэгэн төдий хурааваас ширүүнээр дотрын бэлгэ нь өгүүлэхүй. Огторгуйд сар гарсан мэт болох тэндээс тэр гэгээ нь хураасан хойно маш хоосон хэмээгдэж гэгээ бадрангуй харагдаж арилсан. Огторгуйд нар гарсан мэт улаан ба улбар шар харагдаад бас түүний хураасан хойно **их хоосон** хэмээгдэх. Гэгээд чухлыг олж хараад арилсан огторгуйд завсаргүй хар үүлээр бүрхсэн мэт хав харанхуй болж мэдээ нь шантарч одмуй.

Тэндээс хав харлан одсоноос мэдээгүй болсон тэр арилснаас хамаг **хоосон** хэмээгдэх. Харагдах огторгуйн элдэв өнгийг гурван шалтгаанд эс халдсан. Өөр гийхийн хир үгүй огторгуй мэт наран ургуулж үхэхийн гэрэл мөн чанар болой. Энэ хэмээвээс **гурван гэгээ** зэрэг шингэсэн нүгүүд зүрхний эвдрэмгүйд шингэх хийгээд оройн цагаан дусалд бууж хүйсийн улаан дусал дээш харж, зүрхний дусал шингэхүй цаг тэр нь буюу. Энэ хэмээх үхэхийн зэрэг орон төгөлдөр замбуутивийн хүмүүнд болой. Бусад **гурван сансрын** амьтанд ийм үгүй буй. **Хүн, амьтан төрөл нь умайгаас төрсөн, өндөгнөөс төрсөн, чийг дулаанаас төрсөн, хувилж төрсөн дөрөв** буй. Суух орон нь замбуутив, үхэрт тив, муу дуут тив, үлэмж биет тив. Эдүгээ оронд суугч хүн амьтан нь бий бөгөөс гаталган үл чадах.

Зовлонгүй болбоос **эрж үл олох зовлон**

Хилэгнэх **дайсан лугаа учралдах зовлон**

Чухал **өршөөх нөхрөөс хагацах зовлон** тэргүүтэн цаглашгүй болой.

Дөрвөн тивийн хүний бие хэмжээ нь Замбуутивийн хүний хэмжээ нь дөрвөн тохой болой. Нас нь урт бөгөөс нэг зуун нас түүнчлэн инагш хэмжээгүй. Үхэр тивийн хүний бие нь найман тохой. Нас урт бөгөөс хоёр зуун тавин нас буюу. Түүнчлэн инагш хэмжээгүй үлэмж биет хүн нь арван тохой. Нас нь урт бөгөөс таван зуун нас буюу. Түүнчлэн инагш хэмжээгүй мэт. Муу дуут тивийн хүн нь гучин хоёр тохой. Нас нь лав мянган наслах буюу. Дөрвөн тивийн янз нь Замбуутив дүгрэг. Үхэрт тив гурвалжин, Муу дуут тив дөрвөлжин, Үлэмж биет тив нь найман шинийн сар мэт хэлтгий буюу. Гүшихүйн яруухан насан тэнгэр нар **Дөрвөн Махранз тэнгэр** нарын биеийн хэмжээ нь захын 28 тохой нас нь 40000 буй. **Байлдаанаас хагацсан тэнгэр** нарын биеийн хэмжээ нь 254 тохой буюу нас нь 8000 буюу. **Төгс баясгалант тэнгэр** нарын биеийн хэмжээ нь 512 тохой буюу нас нь нэг түм 6000 нас буюу. Хувилан баясагч тэнгэр, бусдын хувилгааны эрхийг үйлдэгч тэнгэр тэр хоёрын хэмжээ нь насны тоо нь улам улам хоёр төдий буй. Хүсэл зургаан аймаг тэнгэр нар тэр буй.

Дээд өнгөт тэнгэр нарын орон нь арван долоо буюу. Биеийн хэмжээ, насны цаг нь улам дорд. Тэнгэр нарын биеийн хэмжээ насны цагаас дээд өнгөт. Тэнгэр нарын биеийн хэмжээ наснаас нь хоёр тохой буй. Өнгөгүй дөрвөн зүйл тэнгэр нар

нь гэтлэлгүй тэнгэр хаяалалгүй тийн бөгөөд мэдэгч тэнгэр юугаар үгүй тэнгэр нар нь хаяалалгүй тэнгэр, Хаяалалгүй тийн бөгөөд мэдэгч тэнгэр юугаар үгүй тэнгэр, Сансрын үзүүрт **тэнгэр дөрвөн аймаг** буй. Сансрын үзүүрт тэнгэр нарын насны цаг нь нэгэн донхор найман бумтай. Найман түмэн нас буюу гурван сансрын зургаан зүйл амьтны төрлийн дээд нь Замбуутивийн хүмүүн амьтан буй, тэр юуны тул хэмээвээс чөлөөт найман учирсан тэдгээр 18 эрдэм лүгээ төгссөн нь эрдэмт хүний бие мөн. Арван найман ном лугаа эс учирсан хүмүүн нь эрдэнэт хүмүүн бус буй.

Чөлөөт арван найман ном лугаа учирсан хүмүүний бие олохуйяа бэрх, эвдрэх хялбар. Олохуйяа юунд адил бэрх буй хэмээвээс зүүний сүв дээр нэгэн атга цагаан гээц цацваас хаана тогтох тэр мэт бэрх. Нэгэн атга буурцаг чулуун дээр хүчтэй цацваас нэжгээд харваас болох түүнчлэн бэрх. Гүмдаа цэцэг их замд ургах бэрх. Түүнчлэн эрдэнэт хүний бие олохуйяа бэрх. Туулсан бурхан ертөнцөд өөд болохуйяа бэрх. Түүнчлэн эрдэнэт хүний бие олохуйяа бэрх. Далай доторх хөвд модны нүхэнд алтан манашийн толгой орохуйяа бэрх. Түүнчлэн эрдэнэт хүний бие олохуйяа бэрх. Одны гэрэл өдөр үзэгдэх бэрх. Түүнчлэн эрдэнэт хүний бие олохуйяа бэрх.

Эрдэнэт хүний бие олсон ба эвдрэх нь юунд адил буй хэмээвээс усны хөөс мэт. Илбэ хувилгааны худал мэт, өвсөн дээрх шүүдэр мэт. Огторгуйн гилбэлгээн мэт. Үдшийн уулын сүүдэр мэт өнгө нь мөнх бус. Огторгуйн солонго мэт, намрын цэцэг мэт буй. Дууны мөнх бус нь илбэ хувилгааны буу мэт, лууны дуу мэт буй. Биеийн мөнх бус энд хүн бөгөөтөл манагар яс болсон буй. Эд таваарын мөнх бус нь үерийн ус мэт. Ер бүгд мөнх бус шөнийн зүүд мэт болой. Ариухан зүйл амьтанд жаргалангийн чөлөө үгүй нь юунд адил буй хэмээвээс орчлонгийн жаргал зүүний үзүүр мэт хэмжээгээр бөгөөс жаргалангүй буйгаар бууваас жаргалангүй буй. Жаргалыг хүсэх бөгөөс орчлонг тэвчигдэх хэмээн номлов. Гурван сансрын хамаг зовлон үнэмлэх **зовлон** мөний тул тэр юунаас болсон буй хэмээвээс хамаг гарахын орон зовлон үнэнээс төрсөн буй.

Зовлон үнэнийг номлосон энэ тэргүүн бүлэг.

Хамаг гарахуйн орон нь арван хоёр гишүүт ач орон буй. Арван хоёр гишүүт ач орны эргэх нь доор очирт тамаас дээр сансрын үзүүр хүртэл чөлөө завсаргүй модны үзүүр шатсан гэм ирсний хүртэл мэт буй. Тэр юуны тул эргэсэн буй хэмээвээс мунхаг нисваанисаас болсон буй. Мунхаг нисваанис буй хэмээхийн түйтгэр тэдгээр орчлонгийн үндэс буй. Тэдгээр бүгд өөрийн сэтгэлд буй. Түүний тулд өөрийн сэтгэл гэмшин шүлэглэвэй.

Ува сувасди сидадам

Шэрэй шэрэй хамгийг мэдэгчид мөргөмүй.

Өөрийн биеийн таван махбод хэдэн доор таван хорын нисваанисын цэргээр цогцолж, буртаг хирийн өвчний үүлээр бүрхэгдэж нүгэл хилэнцийн ослоор хур оруулна би хэмээн тэмцэх лууны дуугаар дуурсан буруу үзэлт гэлэнгүүд халаар чиглэж тачаангуйн усыг шавраар дүүргэж хатуу урын галын гэрэл бадруулан харанхуй мунхгийн нойрт дарагдаж, хий, шар, бадганыг модны навч дэлгэрүүлэн хор ад чөтгөрийн шингэнийг өрвөлзүүлэн өөрийн биеийг магтахул бусдыг доромжлон худалдагч өглөгийн үүдийг хэрмэн сууцаар тамгалагч шагшаабад хийг

татаангуйн усаар өвтгөн хүлцэнгүйн шатыг ичгүүргүй залиар эвдмүй.

Даяаны баганыг алгасахын хийгээр эвдэж билгийн гэрлийг мунхгийн харанхуйгаар бүрхээд өөрийн сэтгэлийг маш гомдох тэр орноос бус зүгийн таван хорын цэргийн чуулганы ялагдах. Өөрийн зүгийг ариухан чандсаар доройтуулбай. Хий бүрдлээр дүүрсэн таван махбодод би хэмээн баримтлахын үйл юун хэрэг буй. Би хэмээн баримтлахын буруу. Өлзий заяаны нисваанисын элдэв нүгэл хилэнцийг хурааж гурван муу заяаны оронд бас хөтөлж худал хуурмагаар би хэмээн үйлдэгч энэ дайсныг хамаг гарахуйн орон **зовлон үнэний үндэс** мөн буй.

Хамаг гарахуйн зовлон үнэнийг номлогч нөгөө бүлэг

Нэн тэргүүн зовлон үнэний гэмийг мэдэх хэрэг буй. Түүнчлэн хамаг гарахуйн орон зовлон үнэн. Орчлонгийн үндсийг таслах хэрэг буй. Түүнийг таслах арга нь ил буй хэмээвээс тонилохын мөр тэр буй. Тонилохын мөр олох арга нь өөр өөрийн тонилох шагшаабад, санваар, хамаг эрдэм зургаан барамид туулахын орон мөний тулд Шигамуни бурхан найман түмэн дөрвөн мянган цогцос номловой. Үлгэрлэвээс алтан дэлхийд элдэв зүйл бүр үр, навч, цэцгүүд хамгийн орон болсон мөн тул түүнчлэн бурхан бүтсэнээр гээд шарван **Баридарбод** тэргүүтэн дөрвөн зүйл бурсан хуврагуудын болохын шавь энэ болой. Өөр өөрийн тонилохын санваар **хоёр зүйл** болой. Ирдэмэгчийн гэргийт хүмүүний бацаг, гэргий тэвчсэн тойны бацаг нэг тэргүүтэн, гэргийт ертөнцийн хүний бацагт **хоёр зүйл** болой. Нэг өдрийн бацаг, увшийн бацаг хоёр буй. Бацаг⁵ хоёр буй: Нэн урьд нэгэн өдрийн бацаг увшийн бацаг гэргийт хүмүүний буяны дээд мөний тул ач үрийг нь бурханд залбирал болруун. Ганга мөрний тэргүүтэн таван их мөрөн гээд далайн усыг хумхын усаар туулан чадаж нэгэн өдрийн бацгийн ач үрийг туулан үл чадюу Замбуутив дүүрсэн дайныг дарсанд эрдэнэ тэргүүтэн хамаг элдэв зүйлийг өгсний буянаас нэгэн өдрийн бацгийн буяныг юугаар хувилан үл чадаж мянгаар хувилан үл чадюу хэмээн зарлиг болоход нэгэн өдрийн бацаг нэгэнтээ ариутган сахиваас хүслийн ариун тэнгэр нар төрөх болюу хэмээн номловой. Түүнээс ба эдүгээ нэгэнтээ бацгийг ариунаа сахиваас Майдар бурхны шашны ач үр олох болюу.

Бурхан багш Майдарт номлосон сударт арван дөрвөн хийгээд арван таван ба, түүнчлэн битүүн ба, шинийн найман хийгээд их хувилал сард найман гишүүт санваар тэгш ухуулаад санваар хичээгээд гэм алдлыг наманчилбаас миний шашинд үлэмж болюу. Энэ утгыг сайтар номловой. Бас энэ нэгэн өдрийн бацгийг хувилхан сарын шинийн найман, арван дөрвөн, арван таван, битүүний өдөрт сайтар ариутган сахиваас бурхны хутгийг олохын тулд Ргүгэрэн бурханд учран Шинийн найман, арван таван битүүн хийгээд хувилхан сард нэгэн өдрийн найман гишүүт бацгийг ариутган сахиваас тэр өдөр адил болмуй хэмээв.

Ялж төгс нөхчихсөн зарлиг болруун:

Ргүгэрэн ч тийн хэмээн бүү өгүүл. Шинийн найман, арван дөрвөн, арван таван битүүн ба хувилхан сард найман гишүүт бацгийг сахиваас тэр надад адил буй. Тийн хэмээн зарлиг болбой. Нэгэн өдрийн бацгийн ач нь маш үлэмж буюу. Тийн хэмээн сэтгэж орчлонгийн ирдэмэгчийн аливаа оронд сэдвээс зовлонгийн орон хэн лүгээ ханилбаас, зовлонгийн нөхөр аливаа үйл үйлдвээс, зовлонгоос бус

⁵ Шашны ёсонд нэг хоногийн сахил санваар буюу эсвэл мах, тос зэрэг улаан идээ амсахгүй, гагцхүү ном бясалгал хийх тодорхой хугацаатай санваар.

бүдрэх аргагүй тул чөлөөт олохуйяа бэрх, эвдрэх хялбар. Огторгуйн цахилгаан мэт эрдэнэт хүмүүний биеийг олсон цаг дор хүмүүний бие олсон ач авах нь толгойд гэм шатсан мэтэд хичээх хэрэг. Энэ биед буяныг эс хичээж нүгэл хилэнц хийгээд тамд унаваас юун биш үү.

Галав хүртэл жаргалант төрлийн дууг үл сонсож хүний биеийн ач авах арга хамгийн үндэс урьдын итгэл явуулагдахуй мөний тулд Төрвөлгүй багш таван удаа зарлиг болбой. Аливаа итгэл явуулахын орон нь гурван эрдэнэ буй. Бусад итгэл явуулбаас итгэл болох бус буй. Аюулаас айгч хүмүүн нүүгүүд үлэмж уулын ой хийгээд мөчирт модны сайтар нь гэвээс дээд итгэл болмуй. Тийн бөгөөс итгэлийг шүтвээс аюул бүгдээс тонилох болмуй. Аливаа бурхан ном хийгээд бурсан хуврагт итгэл явуулбаас хамаг зовлонгоос тонилох болноу. Ийн хэмээн зарлиг болбой. Энэ ертөнц бэрх ахул хад мэт усан хот балгасын хань нөхөр, хуяг дуулга, мэс тэргүүтэн ертөнцийн онгод тэнгэр, наран, саран тэдгээр бүгд дээд итгэлийн орон үл болох. Итгэлийн орон гурван эрдэнэ мөний тулд Майдарын бодисад зарлиг болбой.

Бурхан ном хийгээд бурсан хуврагууд тонилохуй. Түшигчдийн итгэлийн орон хэмээн зарлиг болбой. *Жигном хэмээх багш зарлиг болруун:*

Гурван эрдэнэд итгэл явуулах тэр бурхнаар бурсан хуврагуудын үйлдэх ном туулсан, эс туулсан хоёроос нөгчсөн итгэл явуулахуй Төрвөлгүй багш, Жиг хаан багш хоёр нэгэн эхээс хамт төрсөн буй. Төрвөлгүй багш 12 жил хүртэл Майдар бурхныг бүтээж төгс жаргалангийн оронд хүрч Майдар бурхны тавин найман их авдар номыг сонсож бас Замбуутивийн Энэтхэгийн газарт таван аймаг номыг хаана дэлгэрүүлэн номлосон буй. Нас нь заримууд мянган наст хэмээмүй. Заримууд таван зуун наст хэмээмүй. Заримууд одоо болтол буй гэж сонсодмуй. Түүний дүү нь Жигном хэмээх багшийн тарни ном, таны гадаад тарни ном, дотоод зөвийн ном хоёрыг нэгэнтээ хоцроолгүй сонсож, өшөө жаран есөн дэвтэр номуудыг цэгцэлж найман мянган хутагт номыг өдөр бүр тасралгүй тугдам болгон бясалгавай. Түүний цол нь **Хамгийг мэдэгч бурхан** хэмээн нэрийдсэн буй. Итгэлийн дээд **гурван эрдэнэд итгэл явуулах** гурван зүйл болой. Нэн тэргүүн их хөлгөнд итгэл явуулах нь би хийгээд хамаг амьтан орчлонгийн зовлонгоос аюугаад гурван эрдэнэд итгэл явуулах тэр их хөлгөн нь итгэл явуулах хэмээгдэж буй хийгээд хамаг амьтан гурван муу заяанаас аюуж гурван эрдэнэд итгэл явуулах нь дунд хөлгөн хэмээгдэж өөрийн биеэ гурван муу заяанаас аюугаад гурван эрдэнэд итгэл явуулах нь өчүүхэн хөлгөн хэмээгдэж, эдгээр **гурван хөлгөн** орчлонгийн гурван муу заяанаас их түймэр шатсан мэт. Түүнчлэн тонилох арга нь ядаж гурван эрдэнэд итгэл явуулахуй. Бурханд итгэл явуулах. Номд итгэл явуулах. Бурсан хуврагуудад итгэл явуулах ёс нь гурван сансрын зовлонгоос тонилохын арга Бурхан багшийн Илт номлосны тул ийн хэмээн бурханд итгэл явуулмуй. Номд итгэл явуулах нь муу заяаны мөрөөс гарч дээд тонилохуйд явагч мөр ном мөний тулд номын эрдэнэ илт итгэлийн орон мөн буй.

Бурсан хуврагуудад итгэл явуулахуй нь их аюулт гурван сансрын далайн аюулаас гарч авах гээхүй ёсоор үзүүлэгч амгаланг тонилохуйн мөрд явахуйд хань нөхөр бурсан хуврагууд мөний тул бурсан хуврагуудад итгэмүй хэмээгдэхүй. Тэнсэлгүй итгэлийн орон лам эрдэнэ буй. Тэр юуны тул хэмээвээс **бурхан, ном, бурсан хуврагууд** тэдгээр бүгд ганц ламд багтахын тулд нэн тэргүүнд итгэмүй хэмээгдэх. Лам, бурхан, ном түүнчлэн лам бурсан хуврагуудын хэр бүхүйн чанар

гагцхүү лам, тэнсэлгүй лам эрдэнэд мөргөмүй. Ламгүй урд Тавара бурхан хэмээх нэрээр үгүй. Мянган галавтаа хамаг бурхан ламд шүтэн бурхан болбой.

Тэнсэлгүй үзүүлэгч бурхан эрдэнэ.

Тэнсэлгүй живэгч ном эрдэнэ.

Тэнсэлгүй удирдагч бурсан хуврагууд эрдэнэ.

Тэдгээр гурван эрдэнэд магад итгэмүй.

Гурван эрдэнийн эрдмийг дурдах үүднээс сүсэг бишрэл төрүүлж итгэл явуулах сүсэг бишрэл юунд адил буй хэмээвээс нүдгүй эцэг эх хоёрт ач ихт хөвгүүн үгүй болбоос түүний нэр нь дурдаад сэцэн биеэ сэрүүцэж нүднээс нулимс гарах мэт. Түүнчлэн лам гурван эрдэнийн нарыг дурдаад биеэ сэрүүцүүлж нүднээс нулимс гарч үнэхээр сүсэг бишрэл төрүүлэхийн ёсон тэр буй.

Адистид авахын арга нь үгүй бөгөөс адистидгүй болох. *Бурхан багш зарлиг болруун:*

Сүсэггүй хүн нугуудад цагаан номууд хаана болох. Гэмд хүлэгдсэн хөрөнгөөс хөх навч, хармаг гарах. Сүсэггүй бөгөөс адистид үл тогтож *Майдар зарлиг болруун:*

Хамаг бурхан ирэн бөгөөтөл сүсэг бишрэл төрүүлэх буй сүсэг бишрэл үгүй болбоос **(17b)** Адистидын хишиг нэгэнт хүртэхгүй буй. Нэгэн онд баян хур хурваас хөмөрсөн савд хур хаана орох. Түүнчлэн сүсэггүй бөгөөс үзүүлэгч багш хур мэт тунаваас сүсэггүй савтанд адистид хаана төрөх. Түүний тулд Мялаарав номловой. Дөрвөн биет лам сэтгэлийн ууланд сүсэг бишрэлийн арга эс харваас Адистидын ёс үл орших сэтгэлийн бишрэлийг давтан баригдахуй. Гурван эрдэнийн адистид авахад нэн урьд сүсэг хэрэгтэй буюу. Сүсэггүй бөгөөс бишрэлгүй. Бишрэлгүй бөгөөс тодорхойгоор үгүй. Дуртгал үгүй болбоос нэрээр үл дагаж нэрээр эс таниваас гурван эрдэнийн адистид олохгүй.

Гурван эрдэнийн адистид эс олбоос тонилох үгүй буй. Түүний тул, ийн хамаг сүсэг бишрэл үүсгэх итгэлийн дээд гурван эрдэнэ мөний тул нэн урьд гурван эрдэнийн бацаг Очирт ламаас авагдахуй. Гурван эрдэнийн бацаг авсны ач нь хамаг төрөл тутам гурван эрдэнээс үл хагацах. Гурван муу заяаны аюулаас сахих. Гурван эрдэнээс хагацалгүй итгэл барин явбаас эцэст бурхны хутгийг олох бэрх бус буй. Түүний тулд, өдөр гурвантаа шөнө гурвантаа итгэл явуулахуй. Түүний тулд, *Мэргэн Жовагэрэв зарлиг болруун:* Гурван эрдэнэд итгэл явуулаад хүчин чадсанаар гурван эрдэнэд тахил өргөгдөхүй. Тахил өргөх нь өдөр, шөнө сэтгэл үл гачлалдахуй. Өөр бусдын бие хэмээн сэгэл, эд таваар тэргүүтэн гурван буяны чуулганыг эрдэнийн сайн магтаал, тахил чуулган хийгээд Самадибадарын тахил хэдий бүхий сэтгэлээр үүсгэж Лам Ядам бурханд барин өргөмүй.

Нигүүлсэхийн эрхээр зөөлөн адистидыг өгөн соёрх. Гурван эрдэнэд итгэхийн бацаг авах ёс нь ариун оронд хэдий бүхий тахилуудыг бэлдсэн. Ариун шагшаабадад төгөлдөр лам багшийн өмнө гурвантаа мөргөж алгаан хамтатган сөгдөөд сүсэг бишрэл үүсгэж, энэ цагаас тэргүүлэн хэзээ бодь хутгийг олох хүртэл гурван эрдэнэд итгэмүй хэмээн гурвантаа ам авахуй ёс нь өөрөө тэр буй. Бацаг сахих ёсон нь өөрийн амиа тэвчтэл бацаг шагшаабад алдалгүй сахигдахуй буй. Бурханд итгэснээр ертөнцийн онгод тэнгэр нарыг тахин үл мөргөгдөхүй. Түүнчлэн арьсан бие, мод, чулуун самбар, бүс торго, цаасан эрдэнэ. Элдэв зүйлд хуниснаар мөн

чанарын түүнчлэн ирсний бие мөн хэмээн сэтгэж мөргөн тахигдахуй. Эвдэрсэн, хагарсан, сайтар эс хийснийг үл доромжлон бишрэгдэхүй. Ном дор итгэх ёс нь хамаг номууд амьтны тусын тулд номлосны тул амьтанд хор үл хүргэх, амьтанд хор хийж номын тангаргаас давбаас бурхан болох үгүй буй. Тэр юун хэмээвээс хамаг амьтныг бурхан хөвгүүн мэт өршөөхийн тул тэр юунд адил хэмээвээс хөвгүүнд хор хийвээс эцэг эх нь үл таалах мэт буй. Бурсан хуврагуудад итгэхүй ёс нь тэрс буруу ном үл үзэгдэх тэрс буруу номтон нь хань нөхөр гэвээс дээд нөхөр бурсан хуврагуудаас Богд ном сонсох бус буй. Дээд нөхөр бурсан хуврагуудаас ном эс сонсооос тонилох мөр дор хаана үгүй нөхөр буй.

Түүний тулд дээд нөхөр бурсан хуврагуудад сүсгээр бишрэгдэх буй, ямар бэ. Дөрвөн зүйл бурсан хувагийг үл доромжлох буй. Санваар шантарсан бурсан хуврагуудыг доромжилбоос Бурхан багш зарлиг болруун. Замбага цэцэг хэдийгээр хагдравч бус цэцгүүдэд адил үл болмуй.

Миний тойн хэдий цаг шантарваас ертөнцийн гэргийт лүгээ адил эс болмуй хэмээн зарлиг болбой. Түүний тул бурсан хуврагуудыг насад даган бишрэгдэхүй буй. Өдрийн нэгэн бацаг авахуй нь шинийн найман, арван дөрвөн, арван таван бүгд эдгээр сайн өдөрт найман гишүүт тэвчтэл сахих.

Авахуй бацгийн гишүүн нь хоцроолгүй сайтар сахь. Сахихын зүйл нь амь үл нядлах, эс өгснийг үл авах, буруу хурьцан үл явах, худал үл өгүүлэх. Тэдгээр дөрвөн үндэс хийгээд найман гишүүт бацаг амиа тэвчтэл сайтар сахихуй. Үлгэрлэвээс дайсныг дарсан амиа тэвчтэл дөрвөн үндэснээ. Найман гишүүт тэвчтэл сахих. Түүнчлэн амиа тэвчтэл сахигдах увш нарын бацгийн зүйл хэмээвээс найм буюу. Итгэл барих увш амь үл тэвчихүй.

Увш хулгай үл хийхүй

Увш дөрвөн үндсийг сахих

Увш ухахуй

Увш бүрэн явдалт

Увш туулсан

Увш таван орныг сахих

Увш эдгээр увшийн найман сахих бацаг нь нэгээс тав хүртэл буй. Амь таслах, тэвчсэний буян нь эвдэрхий үгүй очирт бие олох буй. Эс өгснийг авах тэвчсэний буян нь цаглашгүй эд таваар төгөлдөр хийгээд хумс урт хурууны завсар нь ангархай хөл мэт бат хөлсийг олохуй буй. Ураа хурааж тэвчсэний буян нь эргээд төгс бүрэн бие нь дэлгэрсэн буй. Худал хэлэхийг тэвчсэний буян нь хэл нь нүүр бүтээхүй буй. Дуу нь таван гишүүт эсэрүн аялах мэтийг олох буй. Архи тэвчсэний буян нь арслангийн хүч мэт их хүчийг олох буй. Цаг бус идээг тэвчсэний буян нь дөчин цагаан шүдийг олох буй. Эрх хийгээд үнэрт хүж тэвчсэний буян нь шагшаабадын үнэр нь биед хүж мэт олох буй. Бацгуудыг тэвчсэний буяны хамаг ялсан чимгээр чимэгдсэнийг олох буй. Өндөр их ширээг тэвчсэний буян нь арслант тавцангийн суурь олох буй.

Очирт багш, сургаалын багш гурван эрдэнэд таван цогцсоор мөргөвөөс оройн санваар төгс олох буй. Түүнчлэн ирсний шарил, лам гурван эрдэнийн шүтээн тэдгээрт сүсэг бишрэл таван цогцоор мөргөвөөс буян нь цаглашгүй буй. Түүнчлэн

арилсан бурхан чихээрээ сонсоод гэрэл сахигчид зарлиг болбой. Язгууртны хөвгүүн, язгууртны хүүхэд аливаа сүсэг бишрэлийн таван цогцсоор түүнчлэн ирсний шарил хийгээд гурван эрдэнийн шүтээнд нэгэнтээ мөргөвөөс буян нь хэдий чинээ буй хэмээв. Гэрэл сахигч⁶ өчмүү. Ялж төгс нөгчсөн би эс ухвай номлон соёрх.

Ялж төгс нөгчсөн бурхан зарлиг болруун:

Сүсэг бишрэлийн таван цогцсоор мөргөсний буян нь энэ таван гишүүний доор алтан далай хүртэл шороо тоос хэдий бүхий бөгөөс төдий чинээ мянган хүрдийг орчуулагч хаан төрөх болуу. Тийн хэмээн зарлиг болбой. Гэрэл сахихуй төгссөн орноос босож, нулимс гаргаж бие шимширч алгаа хамтатгаж таван цогцсоор мөргөөд ялж төгс нөгчсөн маш сайн хэмээн номловой.

Мөргөхийн ач үр нь цаглашгүй буй. Тойн бацагт хоёр зүйл буй. Завсраар бацаг орсон чухал туулсан хоёр буй. Тэр хоёр бацагт юуны тул тойн хэмээвээс гурван сансрын орчлонгийн гэргийтэй, эдгээр бүгд хир буртаг, шавар шавардсан буй. Тойны бацаг түүнээс гарч тонилсон буй. Түүний тулд тойны бацагт хэмээгдэхүй.

Орчлонгийн жаргалд тачааж гэргий хийгээд охин, хөвгүүнийг тэвчвээс хэзээд бодь хутгийг үл олж түүний тулд Бурхан багш номловой. Алимад гэргийд ач ямар бөгөөс, дээд хутгийг олсон ба энэ аливаа бурхан урьд ч болсонгүй буй. Эрх төдий ч бөгөөс болох оронгүй хааны төрийг ч бөгөөс нулимс товирхон мэт тэвчигдэхүй. Аглагийг хүсэж чөлөөнд агчид нь нисваанисыг тэвчиж шимнусыг дарваас эхнэргүй бодь хутгийг хураан төгсгөмүй хэмээн номловой. Сайтар орсны ач нь таван зүйл болой: Өөрийн тусыг хольцолгүй олсон хийгээд зардсын ачааг хүндээр ачихыг тэвчсэн ба өөр идвэр үгүй аван тахигчдыг тэвчсэн ба магад үйлдэхүй хийгээдийг тэвчсэн, нирваанаас нөгчин жаргаланг тэнсэлгүй олсон тэдгээр **тав** болой. Бас тойн болсны ач нь тэнгэр хийгээд эрдэнэт хүний бие олбой.

Бурхан хийгээд цэнгэл сонсогч дээд төрөлд төрөх тоолшгүй тойн болуу. Өчүүхэн сонсох сайтар болбой. Хамаг тэнсэхийн орон болох буй. Сайтар орсон хэргийн ихийн тул сайтар орсон буян нь тоолшгүй буй. Гурван сансрын хамаг амьтны эргэлэг хүртэл үр хийгээд гэргий ба өглөг өгсөн буяны ач үрээс тойн болох хэмээн санаж ламын зүгт нэгэн алхах явбаас буян нь түүнээс маш цаглашгүй буй. Идэх, уух хийгээд цэцэг тэргүүлэн элдэв тахилаар арван зүгийн бурхан бодисад нарт тахил өргөсөн буянаас тойн болуу гэж санаж долоон алхам явбаас түүнээс буян нь цаглашгүй түүнээс их буй. Түүний тулд Бурхан багш Хүрдэн орчуулагч хааны төрлийг тэвчиж, өөрийн үсийг өөрөө авч үнэн хүч чадан бөгөөтөл долоон наст эс хүрсэн ба өр төлөөс их авч түүнчлэн буруулж бацаг авсан ба эцэг эх нарын хуулиас эс зөвшөөрсөн ба бие нь өвчинд эзлэгдсэн ба эцэг эхийг алсан ба таван завсаргүй үйлдсэн ба гар, хөл мухар ба шав шар үстэн ба хөөгдсөн ганц хумст ба хөөгдсөн ба хүмүүн бус амьтан ба муу дуутан хүмүүн ба эр мэт эхнэр ба илбэ хувилагч хүмүүн ба бэлгэ хувилагч ба Сэцэн тэнгэр бүгд тойны бацгийн сав үл болох.

Чөлөөт арван найман ном лугаа төгөлдөр хүмүүн бие тийн бөгөөд арилснаас сайтар орох нь дээд буян мөний тул сайтар орохын бацаг авахуйд аливаа багш үл болох багш болохын эрдэм нь хорин таван эрдэмд төгөлдөр болсноор сайн лам болох чанар нь үлэмж. Сургаалд чухлан амарлисан үлэмж

⁶ Сайн цагийн мянган бурхны гуравдагч бурхны нэр. Kasyapa

хичээж эрдмээр баяжихул мөн чанар сайтар онож өгүүлэхүй еэ. Мэргэн өршөөхүйн чанараар тачаан гэрч болон үзэгдэхүй тэр мэт төгс эрдэмт буян удирдагч ламын эрдэм буй. Шавийн эрдэм нь гэмт гурван савыг тэвчсэнийг мэдэхүй ариун ёсонд шүтсэн ба эрдэнэ мэт суут шавийн сайн чанар тэр буй. Тэр мэт шавь, лам, эрдэм авах нь төгс цогт ламын цадигт нэгэн төдийгөөр буруу алжаас үл болон юу үйлдвээс сайтар онож сүсэглэснээр лам адистид ерөөлд орших болтугай.

Түүнчлэн гэмийн үүднээс онож, эрдмийн үүднээс магад бясалгагдах нь хэмжээлшгүй өмсгөл тэвчиж шар улбарыг өмсөөд орчлонгийн цувиралт нь хамаг илт тэвчвэй. Нэн урьд тойн болоход гурван арилчих буй. Ертөнцийн ёс бэлэг тэмдгийг тэвчээд, сайтар болсны тэмдгийг бүтээгдэхүй. Сэтгэл арилчих нь ертөнцийн хүсэхүй, сэтгэлийн таван гэмийг тэвчиж, Нирваанаас нөгчсөн газрын ач үрийг дурдсан. Сац олсон хүсэхүй буй. Наран арилжихуй нь ертөнцийн нарыг тэвчээд цог хийгээд гэрлийн алдаршсан хийгээд сайн ба, ламын заяаны захаас нэрийдэн авах буюу. Энэ ертөнц бүгдийг тэвчиж сайтар болсон буяны тус ихийн тулд Бурхан багш Дөрвөн Махаранз энэ хамаг ертөнц өтлөөд үхэхэд хөтлөгч нь яргачин хонь хөтөлсөн мэт айн тийн бүлтгэнэж явахуй шүтээнгүй буй.


Энэ хамгийг гэж олох мэт үнэмлэх хэрэггүй буй. Энэ хамаг ертөнц сэтгэлээр ханахгүйн тулд үлгэрлэвээс: Архины гэмээр согтож, бас архи эрж явах мэт буй. Энэ хамаг ертөнцийн гэмийг би сайтар илт мэдэж хаан өөрөө тонилж улбар шар хувцастныг мөшөөгөөд арилсан сүсгийн үүднээс хээрээс гэргүй хээрийг тэвчиж сайтар орвой. Ийн хэмээн номловой. Санжилцах цэцэг хийгээд хамаг өмсгөлийг нэгэн өнгө хийгээд энгэсэг мэт их будсан өнгөөр хар, хөх, цайвар, цагаан үсээ урт тавьсан. Тэдгээр бүгдийг тэвчигдэхүй. Хүчин туулшгүй зүгийн осолд үл автахуй,

Тойны бацгийн савд үл болохыг нь дарс, буруу унд дөрөв таван жил хүрч, Хэрээ хөх ч үл чадах хэрэг.

Аливаа шавь ламын ертөнцөөс үл давагдах буй. Түүний тулд Бурхан багш номловой: Нэгэн шүлэг сонссон ба аливаа ламыг эс биширвээс таван зуун төрөл хүртэл. Нохойн төрөл авч эцэст хилэнцэт хорхойд төрөх болюу. Тийн хэмээн номловой. Ламын зарлигаас үл тэвчигдэх буй. Ламын зарлигаас эс давбаас бурхан болох хол бус буй. Адилтгаваас Дэлбэ багшийн Нароб шавь нь хэмээхүй өөрийн хэр арилахын тулд ламын зарлигаас эс давж есөн давхар сүмийн дээр унаж үх хэмээн зарлиг болсонд есөн давхар сүмийн дээрээс унаад шатыг олбой. Наробын шавь нь Марав Лозова багш нь Наробын зарлигаас эс давж Энэтхэгийн аливаа номыг Төвөдийн журганд залж хүргүүлэв. Хэлмэрч Марав Лозова хэмээн алдаршвай. Түүний шавь нь Мялаарав багш нь Марав Лозавын зарлигаас эс давж арван хоёр жил хүртэл есөн давхар байшинг есөнтөө эвдэж есөнтөө барив. Нураах бүрт таар хартал лам юугаа сүсэлж бясалгаж явахуй. Хирүүдийг арилгаж шидийг олбой. **Наян найман нас дээр бурхны хутгийг олж арилсан огторгуйд биеэр өөд болж үзэв.** Ламын адистаар бурхны хутгийг олбой. Түүнчлэн ламын адистид сэтгэлдээ биширч сайтар орсны бацаг авахуйд өршөөнгүй хийгээд магад орохуй сэтгэлийн үүднээс сайтар орохын бацгийг тийн бөгөөд арилсан нь даруй буй. Тэр бацгийг ариунаар сахиж ёс нь бөөсийг чанан амьтны амийг үл таслах. Ивээл чинээ эс өгснийг үл авахуй. Буруу хурьцлыг тэвчигдэхүй. Ямар ба худал үгийг тэвчигдэхүй. Тэдгээр дөрвөн үндсэн арван гишүүт бацаг завсраар орсны бацаг тэр буй. Өмсгөл бэлтгэх нь сэнтий гэсэн. Номт тахил эргэнэг, дэвсгэр, шүүр, бадар аяга

төдий буй. Аливаа хэрэглэх хувьтныг бүртгэх хэрэг. Номт тахилын хэмжээс нь урт нь таван тохой, хөндлөл нь гурван тохой, багана хэмжээс урт нь дөрвөн тохой, нэг төө. Хөндлөл нь хоёр тохой, нэг төө. Дунд нь түүний завсраар буй хийсэн хэмжээ нь урт нь арван хоёр тохой. Хөндлөл нь гурван тохой, баганын хэмжээ нь урт нь дөрвөн тохой нэг төө. Хөндлөл хоёр тохой, нэг төө. Сэнтийн их хэмжээ нь урт нь долоон тохой. Хөндлөл нь хоёр тохой баганын хэмжээ нь хоёр өвдөг бүрхэхийн төдий буй.

Чухал туулсны бацаг сахихын зүйл нь хоёр зуун тав буй. Ач үр нь цаглашгүй. Түүнээс дээр бацаг үгүйн тулд туулсан бацаг хэмээгдэж, туулсан эрслэний бацаг сахих нь шударга дөрвөн номын үлэмж хуврагуудын арван гурван ном магад эс болсон хоёр ном эс тэвчвээс муу заяанд унаж гучин ном өөр өөр наманчлахуй дөрвөн ном ямагт болгохын жаран ном олон сургаалд долоон ном тэмцэлгүй амарлиулагч долоон ном хийгээд хоёр зуун тав буй. Энэ бацгийг нэгэн өдөр сайтар хадгалсан ач үр нь сав ертөнцөд үгүй буй. Зуун адгуусанд өглөг өгснөөс нэгэн эхнэр хүнд өглөг өгсний ач үр нь их буй.



Зураг 1. Гар бичмэлийн сүүлийн хуудас

Зуун эхнэр хүмүүнд өглөг өгснөөс нэгэн эр хүмүүнд өглөг өгсөн ач үр их

Зуун өтөл хүмүүнд өгснөөс нэг увш хүмүүнд өгсний ач үр их

Зуун увш хүнд өгснөөс нэг сайтар болсонд өгсний ач үр их
Зуун сайтар болсонд өгснөөс нэг аяга тахимлагуудад өгсний ач үр их буй. Аяга тахимлагуудад нэгэн өдрийн цав өгсний хүчээр мянга хүртэл орчуулагч хаан болсон буй. Гэлэнгийн бацаг нь Бурхны эргэн шалтгаан мөний тул *Бурхан багш зарлиг болруун:*

Миний ариун шагшаабадад тойн бурхны оронд хүрэх нь нэгэн бүхэл бүсийн завсрын төдий буй. Тонилох мөрд уриныг хүссэний төдий буй хэмээн номломуй. Эхнэр тойн гэлэнгийн бацаг нь гурван зуу буй. Тэдгээр Бурхан багшийн дөрвөн зүйл бурсан хуврагууд аливаа нэгэн зарлигаас үл давахуй давбаас алдал нь их. Ийн тулд **мунхагт төрөөд** Илдэв хэмээх тойн мэт болмуй. Түүний тулд Бурхан багшийн зарлигаас үл давахуй. **Багшийн ёст цааз нь эс сонссон амьтан сонсох хэрэг. Сонссон амьтан цаазаас үл давах хэрэг.** Хэдийгээр давбаас хор идсэн мэт гэмшин наманчлах хэрэг. Өөр өөр тонилох санваар эс олсон, олоод арга олсноо үл шантран сахихын арга шантарваас хар засал тэжээхүйн арга буй. Түүний тулд Бурхан багш бацаг номловой. Ува сайн амгалан болтугай.